МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ХЭРЭГЖИЛТ
(Мэдээлэл лавлагаа)

Р.Хатанбаатар

Монгол Улсын гадаад бодлогын зорилго нь дэлхийн улсуудтай найрсаг харилцаатай байж, улс төр, эдийн засгийн болон бусад салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлэх, хөгжил дэвшлийг хурдасгах замаар улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататгах явдал мөн.

2011 онд Улсын Их Хурал Монгол улсын Гадаад бодлогын үзэл баримтлалыг шинэчлэн, баталсан билээ. Гадаад бодлогын үзэл баримтлалд “Монгол Улсын аюулгүй байдал, язгуур ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр-дипломатын аргаар хангах нь гадаад бодлогын тэргүүлэх зорилт мөн. Монгол Улс энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулна” хэмээн заасны дагуу манай улс нээлттэй, идэвхтэй гадаад бодлогоо хэрэгжүүлж байна.

Монгол Улсын гадаад бодлого нь улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан-технологи, соёл, хүмүүнлэгийн гадаад бодлого, гадаадад байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалах, гадаад суртчилгаа, олон нийттэй харилцах бодлого гэсэн харилцан уялдаа бүхий үндсэн хэсгүүдээс бүрдэх бөгөөд улс төрийн гадаад харилцааны бодлого тодорхойлогч шинжтэй байна.

Улс төрийн гадаад харилцаа

Монгол Улсын улс төрийн гадаад харилцааны бодлогын зорилго нь тус улсын аюулгүй байдал, хөгжил дэвшлийг хангах таатай гадаад орчин бүрдүүлэх, дипломат болон консулын харилцаа хөгжүүлэх, нөлөө бүхий улсуудтай харилцааныхаа түвшнийг дээшлүүлэх, олон улсын байгууллага дахь үйл ажиллагаагаа идэвхжүүлэх, дэлхий нийтийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулахад оршино.

1. Монгол Улсын гадаад харилцааг өргөжүүлэх үүднээс 2011 онд манай улстай дипломат харилцаагүй, НҮБ-ын гишүүн 45 улстай дипломат харилцаа тогтоох зорилт тавьсан. Дипломат харилцаа тогтоосноор тухайн улстай хоёр талын болон олон улсын байгууллагуудын хүрээнд бие биенээ харилцан дэмжиж хамтран ажиллах илүү боломж нээгдэх юм. Одоогийн байдлаар 27 улстай дипломат харилцаа тогтоох хамтарсан мэдээнд гарын үсэг зурж, улмаар УИХ-аар соёрхон батлуулснаар манай улс 176 улстай дипломат харилцаатай болоод байна

2. Манай улс Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага / АПЕК/-ын гишүүн эдийн засгаар нэгдэх, Зүүн өмнөд Азийн орнуудын нийгэмлэг / АСЕАН/-ийн яриа хэлэлцээний түнш, Зүүн Азийн дээд түвшний уулзалтын оролцогч орон болох зорилт тавин ажиллаж байна.

   Бүс нутгийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэх зорилтын хүрээнд манай улс Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага /ЕАБХАБ/-ын оролцогч орон, Умард Атлантын гэрээний байгууллага /НАТО/-гийн түнш орон, Зүүн Ази, Латин Америкийн хамтын ажиллагааны чуулга уулзалт /ФЕАЛАК/-ын гишүүн болов.

   Хөрш хоёр орон, АНУ, НАТО-гийн гишүүн орнууд, Европын Холбоо, Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудтай аюулгүй байдал, батлан хамгаалах салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хөгжүүлж, олон улсын энхийг дэмжих үйл ажиллагаанд идэвхтэй оролцож ирлээ.

Ази, Номхон далайн бүс нутаг Зүүн Ази, түүний дотор Зүүн хойд Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааны механизм бий болгоход чиглэсэн үйл ажиллагааг идэвхтэй явуулж байна.

3. Олон улсын тавцанд өөрийн улсын байр суурийг бэхжүүлэх, эх орноо сурталчлан таниулах чиглэлээр идэвхтэй ажиллав. Манай улс дэлхийн 140 гаруй орныг эгнээндээ нэгтгэсэн, ардчиллын төлөөх хөдөлгөөн болох Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэг /АОХН/-ийг 2 жилийн хугацаанд амжилттай даргалж, гишүүн орнуудын Сайд нарын бага хурлыг Улаанбаатарт зохион байгуулав.

4. Монгол Улсын олон улсын аюулгүй байдлыг баталгаажуулах асуудлаарх Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн тогтоолуудын үзэл санааг хэрэгжүүлэх чиглэлд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөлийн гишүүн орнууд, олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж ирлээ.

   Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусын тухай цөмийн зэвсэгтэй 5 гүрний Хамтарсан Тунхаглал болон Монгол Улсын Тунхаглалд 2012 оны 9 дүгээр сарын 17-нд Нью-Йорк хотноо гарын үсэг зурсан нь манай улсын аюулгүй байдлыг олон улсын хэмжээнд баталгаажуулсан нэн чухал алхам болсон гэж дүгнэж байна.

5. Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагууд болон олон улсын санхүү, худалдаа, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа идэвхжүүлэн ажиллаж байна.

6. Монгол Улс олон улсын эрх зүйг хүндэтгэн сахиж, гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлж ирсний зэрэгцээ олон улсын гэрээний тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн зохицуулалтыг боловсронгуй болгож, шинэчлэх чиглэлээр ажиллаж байна.

   Зайлшгүй нэгдэн орох шаардлагатай болон нэгдэн орсон тохиолдолд тухайн гэрээгээр хүлээсэн үүргээ эрх зүй, санхүү зэрэг бүх талаас нь биелүүлэх боломжтой олон улсын гэрээнд нэгдэн орох бодлого, зарчим баримталж, нэгдэн орсон олон талт гэрээний хэрэгжилтийн тайлан, илтгэлийг тогтсон хугацаанд шаардлагын дагуу боловсруулж, холбогдох дээд байгууллагад хүргүүлэх, хамгаалах тогтолцоо бүрдүүлэх, энэ асуудлаарх байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах чиглэлээр ихээхэн ахиц гарлаа.

7. ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, хоёр улстай харилцаж ирсэн түүхэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзан сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлж байна.
   2006 онд Монгол улс, ОХУ-ын харилцааг стратегийн түншлэлийн үзэл санаагаар хөгжүүлэх, 2009 онд стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай тунхаглалд Ерөнхийлөгч нарын харилцан айлчлалын үеэр гарын үсэг зурсан. Түүнчлэн Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр байгуулах чиглэлээр ажиллаж байна.

   2011 онд Монгол улс, БНХАУ-ын хооронд стратегийн түншлэлийн харилцааг тогтоон хөгжүүлэхээр тохиролцсон юм.. Улс төрийн итгэлцлийг бэхжүүлэх, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг чанарын шинэ түвшинд гаргах, хүмүүнлэгийн солилцоог идэвхжүүлэх, олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх нь Монгол, Хятадын стратегийн түншлэлийн гол агуулга байна гэж хоёр тал үзсэн.

2013 онд Монгол Улсын Ерөнхий сайд БНХАУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр хоёр тал “Монгол, Хятадын стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр”-ийг байгуулсан.

8. “Гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд өндөр хөгжилтэй ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж байна.

   Монгол Улс АНУ-тай Иж бүрэн түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж байна. Шинэчлэлийн Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт АНУ-тай стратегийн түншлэлийн хүрээнд хамтран ажиллах гэж тусгагдсаны дагуу харилцааны түвшинг ахиулан “стратегийн түншлэл”-ийн хүрээнд хамтран ажиллах сонирхолтой байгаагаа монголын тал тогтмол илэрхийлж ирлээ.

   Манай улс 1997 оноос хойш Япон Улстай хөгжүүлсэн иж бүрэн түншлэлийн харилцааг шат ахиулж, Стратегийн түншлэлийн түвшинд хөгжүүлэхээр 2010 онд тохиролцсон. Монгол Улсын Ерөнхий сайдын 2013 онд Япон Улсад хийсэн айлчлалын үеэр Монгол, Японы стратегийн түншлэлийн Дунд хугацааны хөтөлбөрийг байгуулав. Мөн Япон Улстай эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах чиглэлээр эрчимтэй ажиллаж байна.

   Сүүлийн жилүүдэд хийгдсэн дээд, өндөр хэмжээний айлчлалын явцад 2011 оноос Бүгд Найрамдах Солонгос Улс, 2009 оноос Бүгд Найрамдах Энэтхэг Улс, 2011 оноос ХБНГУ-тай хоёр талын харилцааг “Иж бүрэн түншлэл”-ийн түвшинд дэвшүүлэн хөгжүүлэхээр тус тус тохиролцоод байна.

   Монгол Улс Бүгд Найрамдах Турк улстай 2005 оноос эхлэн “Иж бүрэн түншлэл”-ийн харилцаа хөгжүүлж байсан бол 2013 онд харилцааны түвшнийг стратегийн түвшинд хүргэж ажиллахаар тохироод байна.

Эдийн засгийн гадаад харилцаа

Үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, эдийн засгийн аюулгүй байдлыг баталгаажуулах, хүн амын амьжиргааны түвшнийг дээшлүүлэхэд гадаад харилцааны үр нөлөөг нэмэгдүүлэх нь эдийн засгийн гадаад харилцааны бодлогын зорилго мөн.
Эдийн засгийн гадаад харилцааг хэрэгжүүлэхдээ:

- Эрх тэгш, харилцан ашигтай байх зэрэг нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээг чанд мөрдөн, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын заалтыг үндэс болгон эдийн засгийн аюулгүй байдлыг бүх талаар хангахыг эрмэлзэж, аль нэг улсаас хэт хараат байдалд орохоос сэрэмжлэх;
- Эдийн засгийн салбаруудад тэргүүний технологи, менежмент нэвтрүүлж, ажил, үйлчилгээ, бүтээгдэхүүний чанар, стандартыг олон улсын жишиг, түвшинд ойртуулан нийцүүлэх замаар өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх, экспортын хэмжээг өсгөхийг дэмжих;
- Олон улс, бүс нутгийн эдийн засгийн интеграц болон дэд бүтцийн сүлжээнд нэгдэхийг эрмэлзэх, далайн боомт хүрэх, дамжин өнгөрөх зам, тээврийн таатай нөхцөл бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Гадаад худалдааг эдийн засгийн өсөлт, хүн амын эрэлт хэрэгцээг хангахад чиглүүлж, үр ашгийг нь дээшлүүлэх, гадаад худалдааны тааламжтай нөхцөлүүдийг олох замаар өөрийн бараа, үйлчилгээний зах зээлийг тэлэх нөхцөл бүрдүүлэх; зэрэг үндсэн зарчмыг баримталж байна.

1. Монгол Улс, ОХУ-ын хооронд худалдааны нийт бараа эргэлт 2013 онд 1.626 сая ам.долларт хүрч, импорт 1561,9 сая ам.доллар, экспорт 61,8 сая ам.доллар болсон бөгөөд худалдааны алдагдал 1,5 тэрбум ам.доллартай тэнцүү гарсан болно. Манай улсын 2013 оны нийт экспортын 1,5 хувь, импортын 23,9 хувь эзэлж, гадаад худалдааны нийт алдагдлын 65,9 хувь нь ОХУ-д ноогдсон байна.

   Манай хоёр улсын хоорондын худалдаа өнгөрсөн жилүүдэд нийт дүнгээр жил ирэх тусам өсөн нэмэгдэж байгаа ч худалдааны алдагдал их хэвээр байна. Энэ нь нефть бүтээгдэхүүний хэрэгцээг бараг 100 хувь Оросоос импортлон хангадаг, экспортын хувьд тээврийн өндөр зардал, Оросын талын гааль болон тарифын бус саад тотгор, Монголын мах, махан бүтээгдэхүүнд оросын талаас тавьж буй мал эмнэлгийн хорио цээртэй холбоотой.

   Хоёр тал Монгол, Оросын хоорондын худалдааг либеральчлах, худалдааны алдагдлыг багасгах, улмаар арилгах, Монголын экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцоод байна. Худалдааг либеральчлах ажлын хүрээнд Монгол Улсыг Гаалийн холбоонд элсүүлэх саналыг оросын талаас тавиад байгаа бөгөөд энэ нь эдийн засгийн хувьд үр ашигтай эсэх болох бусад ямар үр дагавартай болохыг нарийвчлан судлах шаардлагатай.

2. БНХАУ нь сүүлийн 10 гаруй жил манай гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын хамгийн том түнш байсаар байна. Хоёр орны худалдааны нийт бараа эргэлт 2013 онд 5.4 тэрбум ам.доллар болж, экспорт 3.7 тэрбум ам.доллар, импорт 1.78 тэрбум ам.долларт хүрчээ. Улсын хэмжээнд нийт экспортын 91.4 хувь, импортын 30 хувь нь БНХАУ-д ногдож байна.

   БНХАУ-аас олгосон буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй болон бусад зээлийг ашиглах шийдвэр гаргах, цаашид авах зээл, тусламжийн талаарх бодлого, чиглэлийг тодорхой болгох; уул уурхай, дэд бүтэц, хөдөө аж ахуй, санхүүгийн зэрэг салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх; чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах; БНХАУ-аас авах импортын барааны чанарт тавих хяналтыг сайжруулах замаар хүн амын хүнсний аюулгүй байдлыг дээшлүүлэх; уул уурхайн бүтээгдэхүүн, нүүрс, эрдэс баялгийн экспортын зах зээлийг тогтвортой байлгах үүднээс тодорхой бүтээгдэхүүнээр, тухайлбал, нүүрс нийлүүлэх ерөнхий хэлэлцээр байгуулах чиглэлээр ажиллах зэрэг асуудалд анхаарал хандуулан ажиллаж байна.

   ОХУ, БНХАУ-тай дамжин өнгөрөх тээвэр, холбогдох хөнгөлөлтийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх нь манай улсын эдийн засгийн гадаад харилцааны тулгамдсан асуудлын нэг юм.

3. “Гуравдагч хөрш”-ийн бодлогыг хэрэгжүүлэх, АНУ-ын бодит сонирхлыг Монгол Улсад бий болгох, тус улсын хөрөнгө оруулалтыг дорвитой нэмэгдүүлэхийн тулд 2013 онд “Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс хоорондын хэлэлцээр”-т Нью Йорк хотноо гарын үсэг зурсан. АНУ-тай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах чиглэлээр ажиллаж байна.

   Япон Улстай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг байгуулахаар ажиллаж байна. Энэ хэлэлцээрийг байгуулснаар хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцааг шинэ шатанд гаргах, эдийн засгийн салбаруудад тэргүүний технологи, менежмент нэвтрүүлэх, Монгол Улсад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мэдлэгт суурилсан үйлдвэрлэл хөгжүүлэх үндэс тавигдана гэж үзэж байна.

4. ХБНГУ-тай ашигт малтмал, аж үйлдвэр, технологийн салбарт хамтран ажиллах Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулж, энэ хэлэлцээрийн хүрээнд германы дэвшилтэт техник, технологийг ашиглан, нүүрснээс шингэн түлш гаргах үйлдвэр байгуулах, Технологийн хамтарсан дээд сургууль байгуулах зэрэг томоохон төсөл хөтөлбөрүүд амжилттай хэрэгжиж эхлээд байна. Дэд бүтцийн салбарт Германтай харилцаа, хамтын ажиллагаа эрчимжин агаарын тээврийн салбарт германы агаарын тээврийн Люфтханза компани, төмөр замын салбарт германы төмөр зам- Дойчэ Баан компанитай хамтран ажиллахаар гэрээ хэлэлцээ байгуулан, яриа хэлэлцээ хийж байна.

5. Их Британи, Франц улсуудтай худалдаа, эдийн засгийн салбарын хамтын ажиллагаа идэвхтэй хөгжиж, Их Британий Рио Тинто компани, Францын Арева компани зэрэг дэлхийн хэмжээний томоохон компаниуд Монгол улсад идэвхтэй ажиллаж байна. Гэхдээ эдгээр компаниудын эргэн тойронд үүсээд буй нөхцөл байдал нь эдийн засгийн харилцаанд сөргөөр нөлөөлж байгаад анхаарал хандуулах шаардлагатай юм.

   Цаашид Монгол Улсын ашиг сонирхлыг олон улсын худалдаа, эдийн засгийн байгууллагуудтай хамтран ажиллах хүрээнд болон хоёр талын түншлэл, дээд түвшний уулзалт, яриа хэлэлцээний аргаар бататгах; гадаадаас авч буй бараа бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээнд судалгаа хийж аль нэг улсаас хэт хараат байдалд орох, монополь байдал үүсэхээс сэргийлэх талаар эрчимтэй ажиллах шаардлага тулгарч байна.

Гадаадад байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах бодлого

Монгол Улсаас гадаад улсад суугаа бүрэн эрхт төлөөлөгчийн газар өөрийн иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны эрх ашгийг үндэсний болон тухайн улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний хүрээнд хамгаална. Бүрэн эрхт төлөөлөгчийн газрууд өөрийн суугаа болон хавсран суугаа улсад амьдарч, ажиллаж, суралцаж байгаа иргэдийнхээ бүртгэл, судалгааг хөтөлж, тэдэнд шаардлагатай үед туслалцаа, дэмжлэг үзүүлэх ажил жигдэрлээ. Хилийн чанадад ажиллаж, амьдарч байгаа монгол иргэдийн талаарх нэгдсэн мэдээлэл, судалгааг 2013 оны 3-5 дугаар саруудад ДТГ-уудаар дамжуулан хийсэн. Гадаадад гэрээгээр ажиллаж байгаа иргэдийнхээ нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр хэд хэдэн улстай хамтран ажиллаж, нэлээд үр дүнд хүрлээ.

Хилийн чанад дахь монгол иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах чиглэлээр хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодисын хил дамнасан наймаанаас иргэдээ хамгаалах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тодорхой алхам хийхээр холбогдох газартай хамтран ажиллаж байна

Иргэдэд гадаадад зорчих эрх зүйн таатай нөхцөл бүрдүүлэх талаар ихээхэн ахиц гарлаа. Мөн гадаадад ажиллаж, амьдарч байгаа иргэд эх орондоо эргэн ирж, хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулахыг дэмжсэн бодлого хэрэгжүүлж байна.

Төрийн гадаад бодлого нэгдмэл байх, гадаад харилцаанд үндэсний ашиг сонирхлыг дээдлэх зарчмыг тууштай хэрэгжүүлэх талаар

2010 онд Засгийн газраас “Гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдсэн зохицуулалтыг сайжруулах тухай” 162 дугаар тогтоолыг батлсан. 162 дугаар тогтоолын гол зорилго нь зөвшилцөлгүйгээр айлчлал зохион байгуулдаг, яриа хэлэлцээ хийдэг, гэрээ хэлэлцээр байгуулдаг байдлыг нэгдсэн зохицуулалтад оруулж, төрийн байгууллагын ажлын уялдааг сайжруулах, улмаар гадаад бодлогоо “нэг цонх”-оор харах, гадаад харилцааны үр өгөөжийг дээшлүүлэхэд оршиж байсан.

Төр, засгийн байгууллагуудын гадаад харилцааны бодлого, үйл ажиллагааг уялдан зохицуулах аргачлалыг тодорхой болгох үүднээс Гадаад харилцааны яам “Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам”-ыг боловсруулан, 2013 онд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Энэхүү журам нь төр, засгийн байгууллагуудыг гадаад бодлого, үйл ажиллагааны талаар нэгдсэн зөвлөгөө, зааврааp түргэн шуурхай хангаж, төв, орон нутгийн бүх түвшинд үндэсний нийтлэг ашиг сонирхлыг хамгаалахад ач холбогдолтой юм. Энэхүү журмыг төрийн бүх шатны байгууллага үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

* * *